

БАТЛАВ:



2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

# **БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ АВТО МАШИН ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРТ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛСАН :**

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮН:

Б.ДОРЖНЯМБУУ

Ц.ЗАГАРСҮРЭН

Н.МӨНХЖАРГАЛ

З.ЗОРИГТБААТАР

Б.ДАВААДАВГА

**ХӨӨВӨР  
2020**

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2020.01.31

**БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗАРТ АВТО МАШИН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

**Тендер  
шалгаруулалт  
гэрээний нэр:**

Баруунбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын  
газарт авто машин нийлүүлэх тендер  
шалгаруулалт

**Тендер  
шалгаруулалтын  
гэрээний дугаар:**

№ [ӨВАОНӨГ/202001070](#)

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газарт авто машин худалдан авах тендер /[ЭВАОНӨГ/202001070](#) /-ийг нийлүүлэх тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 11 цаг]-аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн [11 цаг 30 минут]-д Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газар /209/ тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**(Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Засаг даргын тамгын газар, холбогдох утасны дугаар: 99323535, 99741453)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Бэлтгэж ирүүлэх ТШӨХ-д заасан бусад материал.
4. **Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
  - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨЭЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨЭЗ 1.1</b>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу баталгаажуулсан үнийн санал ирүүлэх</li> <li>2. Нийлүүлэлтийн баталгаажуулсан график ирүүлэх</li> <li>3. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар</li> <li>4. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх банкнаас ирүүлэх</li> <li>5. Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар 1 жилтэй холбоотой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх. /Хугацаа тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байх/</li> <li>6. Харилцагч Нийгмийн даатгалын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагаа тодорхойлолт ирүүлэх. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/</li> <li>7. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: /2019/ оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хуулбарыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд e-balance-аас тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана.</li> <li>11. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>12. Тендерт оролцогч аж ахуй нэгж нь тендерийн баримт бичгийн дагуу материалаа эмх цэгцтэй, харагдахуйц тод бэлтгэж ирүүлнэ. /Ирүүлсэн материалын харагдах байдал хангалтгүй тохиолдолд тухайн материалыг хангалтгүйд тооцож үнэлгээнд харгалзахгүй/</li> <li>13. Тендерт шалгарсан тохиолдолд нийлүүлэгч нь өөрийн зардлаар барааг хүлээлгэн өгнө. Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Аймгийн төсвийн хөрөнгөөр</b></li> </ol>

<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Байгууллагын хаяг: [Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.]  Огноо: <b>2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Цаг: 11 цаг 00 минут</b></p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг:  Давхар болон өрөөний дугаар: [ <b>Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын Засаг даргын тамгын газар (хоёр давхар, ЗДТГ-ын даргын өрөө)</b>]  Огноо: <b>2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн</b>  Цаг: [ <b>11 цаг 30 минут</b>]</p>
<p><b>ТӨӨЗ 6.2</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь [ <b>авто машин нийлүүлэх багц</b>]-ээс бүрдэнэ:</p>

**Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
 ГАЗАРТ ХУДАЛДАН АВАХ МАШИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА,  
 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

<b>Д/Д</b>	<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>ШААРДЛАГА</b>
1	Үйлдвэрлэсэн он	2004 ба түүнээс хойш
2	Үйлдвэрлэсэн улс	Япон
3	Машины марк төрөл	Toyota land-100 буюу түүнтэй дүйцэхүйц
4	Хөдөлгүүр/ моторын багтаамж/	4000 cc түүнээс дээш /дүйцэхүйц/
5	Кроп хөтлөгч	Автомат
6	Хамгаалалтын нөхцөл	Мосттой
7	Дугуйн нөхцөл	Запас дугуйтай байна.
8	Явах эд анги	Мотор, кроп, хойд урд редукторын тос тосолгоо, хийгдсэн байх
9	Шатахуун зарцуулалт	100 км-т 20 л ба түүнээс бага
10	Жолооны хүрд	Баруун талдаа
11	Нэмэлт нөхцөл	Нийлүүлж буй авто машин нь дагалдах хэрэгсэл /Салон нь өнгө үзэмж сайтай, цэвэрхэн, ухралтын камертай, шинэ запас дугуй, домпрат, түлхүүрүүд, суудлын бүрээс шинээр хийгдсэн/
12	Хөтлөгч	4*4 /дүйцэхүйц/
13	Суудлын тоо	5 ба түүнээс дээш /дүйцэхүйц/
14	Хаалганы тоо	5 ба дүйцэхүйц
15	Өнгө	Сэв замаскгүй, өнгө үзэмж сайтай, цагаан, мөнгөлөг ба түүнтэй /дүйцэхүйц/
16	Шатахууны нөхцөл	Бензин /дүйцэхүйц/
17	Бусад нөхцөл	Авто машин 2019 онд татварын даатгал төлсөн, оношлогоонд оруулсан баримт бичгийг дагалдуулна. Бичиг баримтын зөрчилгүй байна. Мотор болон явах эд ангиас тос шингэн гоожоогүй, хаалганд дуу ороогүй кабины битүүмж алдагдаагүй. Гэрэл дохио өнгө үзэмж алдаагүй тусгал хэвийн, Үйлдвэрийн будгаас өөр будаг замаска хийгдээгүй. Тоормозны наклад солигдсон шинэ элдэв дуу гардаггүй байх.
18	Баталгаат хугацаа	1 Жил
19	Фото зураг ирүүлэх	тендерийн материал нийлүүлэх барааны фото зургийг гадна 4 талаас авсан зураг, дотоод салоны иж бүрэн зургийг тендерийн материалд хавсарган ирүүлнэ.

-----oO-----

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
Тендерийн нийт үнэ					

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаар хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [0] жил байна.  |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [14] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Нийлүүлэгдэх барааг захиалагч ЗДТГ-ын холбогдох ажилтан зарлагын баримт нэхэмжлэх, санхүүгийн баримтаар хүлээн авч баталгаажуулна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>4) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ul> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p>  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>[ 100 ]<sup>1</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>                  | <p>9.1. Алданги оногдуулах хувь: <b>[0.5 хувь]</b></p> <p style="padding-left: 40px;">Алдангийн нийт дүн: <b>[10 хувь]</b></p>  |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_ -наас \_\_\_\_\_ оны дугаар сарын \_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*